



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 420

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 14 нэрийн нийт 34,711,870.00 (гучин дөрвөн сая долоон зуун арван нэгэн мянга найман зуун далан) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 18,238,295.00 (арван найман сая хоёр зуун гучин найман мянга хоёр зуун ерэн таван) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Шинжлэх ухааны академийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Авид, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн захирал О.Янжмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн
№ 0. дугаар тогтоолын хавсралт

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ,
АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)		Цаашид ашиглах хугацаа (жил)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)
					Улдэгдэл өртөг	Улдэгдэл өртөг		
1	Samsung 3400f принтер	2014-01-01	1	299,000.00	299,000.00	0.00	3.00	299,000.00
2	Erson L210 Принтер	2014-01-01	1	350,000.00	350,000.00	0.00	3.00	350,000.00
3	Heatb'уuk, проектор, дэлгэцийн үнэ	2016-01-01	1	2,377,000.00	2,377,000.00	0.00	3.00	1,188,500.00
4	Суурин компьютер	2016-01-01	1	3,113,000.00	3,113,000.00	0.00	3.00	1,556,500.00
5	Электрон самбар	2017-02-01	1	2,300,000.00	2,300,000.00	0.00	3.00	1,150,000.00
6	Канон IR2018N	2016-01-01	1	1,760,000.00	1,760,000.00	0.00	3.00	880,000.00
7	Ширээний компьютер	2017-01-01	15	18,249,660.00	18,249,660.00	0.00	3.00	9,124,830.00
8	Суурин компьютер IMac 27 inch	2017-01-01	1	3,299,000.00	3,299,000.00	0.00	3.00	1,649,500.00
9	Хөргөгч жижиг /Захирлын/	2011-01-01	1	80,000.00	80,000.00	0.00	3.00	80,000.00
10	фото аппарат, диктафон	2011-01-01	1	248,500.00	248,500.00	0.00	3.00	124,250.00
11	Sony 32W 654A TV зурагт	2010-01-01	1	899,990.00	899,990.00	0.00	3.00	449,995.00
12	Ус цэвэршүүлэгч төхөөрөмж	2010-01-01	1	728,020.00	728,020.00	0.00	5.00	728,020.00
13	Дахин үнэлсэн шкаф номын тавиур	2010-01-01	1	307,700.00	307,700.00	0.00	5.00	307,700.00
14	Хувцасны шүүгээ	2010-01-01	1	700,000.00	700,000.00	0.00	5.00	350,000.00
				34,711,870.00	34,711,870.00	-	-	18,238,295.00
НИЙТ ДҮН				(гучин дөрвөн сая долоон зуун арван нэгэн мянга найман зуун далан)		-	-	(арван найман сая хоёр зуун гучин найман мянга хоёр зуун ерэн таван)